



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 630

Улаанбаатар хот

**Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө  
бүртгэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт (Эрүүл мэндийн сайдын багц)-аар санхүүжүүлж бий болсон 13 нэрийн, нийт 61,326,126,813.00 (жаран нэгэн тэрбум гурван зуун хорин зургаан сая нэг зуун хорин зургаан мянга найман зуун арван гурван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Нийслэлийн өмчийн харилцааны дарга, аймгуудын Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.3. Хөрөнгийн давхар бүртгэлийг залруулах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137000084

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны... дүгээр сарын... ны өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ /ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ/-ЭЭР БАРЬСАН  
 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ /БАРИЛГА БАЙГУУЛАМЖ/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөг/	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Эрүүл мэндийн төвийн барилга (УБ, ХУД, 12-р хороо)	Өрхийн эмнэлгийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьтой 2 давхар 24x15м барилга, 7.2x6.8м граж	1,993,795,385.00	2020.12.11	НЗД-ын 2020 оны А/1022 захирамж шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг	Эрүүл мэндийн төв (УБ, ХУД, 12-р хороо)
2	Эрүүл мэндийн төвийн барилга (Хэнтий аймаг Хэрлэн сум, Өлзийт тосгон)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар 12.4x20.4м, 6.10x10.2м барилга	1,043,234,829.00	2021..08.09	21/2021	Эрүүл мэндийн төв (Хэнтий аймаг Хэрлэн сум, Өлзийт тосгон)
3	Эрүүл мэндийн төвийн барилга (Говь-алтай аймаг Дарив сум)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар 12.4x20.4м, 6x12м 1 давхар туслах барилга	1,289,030,488.00	2019.09.28	КА-024/2019	Эрүүл мэндийн төв (Говь-алтай аймаг Дарив сум, )
4	Эрүүл мэндийн төвийн барилга (Говь-алтай аймаг Халиун сум)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар 12.4x20.4м, 6x12м 1 давхар туслах барилга	1,399,982,988.00	2020.08.17	КД-40/2020	Эрүүл мэндийн төв (Говь-алтай аймаг Халиун сум)

5	Халдварт, сүрьегийн эмнэлгийн барилга (Хөвсгөл аймгийн Мөрөн сум)	Халдварт, сүрьегийн эмнэлгийн зориулалттай, 2 давхар 38.4x13.8м, 12x15м, 30 ортой барилга	1,955,210,810.00	2019.12.06	УКД-2019/48	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг (Хөвсгөл аймгийн Мөрөн сум)
6	Эрүүл мэндийн төвийн барилга (Архангай аймгийн Эрдэнэмандал сум)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 1 давхар 34x22м, 15 ортой барилга	1,383,036,825.00	2020.10.12	ББАОКД-2020/36	Эрүүл мэндийн төв (Архангай аймгийн Эрдэнэмандал сум)
7	Хүүхдийн эмнэлгийн барилга (Баянхонгор аймгийн Баянхонгор сум)	Эрүүл мэндийн зориулалттай, 30x18м 3 давхар 50 ортой барилга	2,897,865,510.00	2019.09.12	2019/01	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг (Баянхонгор аймгийн Баянхонгор сум)
8	БНД-ийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга (УБ, Багануур дүүрэг)	Эрүүл мэндийн зориулалттай, 36x16м 50 ортой барилга	2,396,049,868.00	2020.12.28	БА-312/2020	БНД-ийн нэгдсэн эмнэлэг (УБ, Багануур дүүрэг)
9	Эрүүл мэндийн төвийн барилга (Сэлэнгэ аймгийн Мандал сум Түнхэл тосгон)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар 24x12м, 6.2x12м барилга	1,194,996,256.00	2020.12.17	БУ-114/2020	Эрүүл мэндийн төв (Сэлэнгэ аймгийн Мандал сум Түнхэл тосгон)

10	300 ортой төрөх эмнэлгийн барилга (УБ, ХУД.)	Төрөх эмнэлгийн зориулалттай, А блок 51х20м 8 давхар, Б блок 51х20м, 7 давхар, Г блок 15х21м 7 давхар, Д блок 15х21м 2 давхар, Е блок 21.6х12м 1 давхар, Ж блок 12х6м 1 давхар барилга	38,778,755,032.00	2020.07.08	340/2020	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр (УБ, ХУД.)
11	Эрүүл мэндийн төвийн барилга (Архангай аймгийн Хайрхан сум)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар 20.4х12.4м 10 ортой барилга	1,179,580,936.00	2021.10.08	ББАОКД-2021/41	Эрүүл мэндийн төв (Архангай аймгийн Хайрхан сум)
12	Эрүүл мэндийн төвийн барилга (Сүхбаатар аймгийн Дарьганга сум)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар 12.4х20.4м, 6.10х10.2м барилга	915,588,682.00	2019.06.20	СҮ-006/18	Эрүүл мэндийн төв (Сүхбаатар аймгийн Дарьганга сум)
13	Эрүүл мэндийн төвийн барилга (Ховд аймгийн Жаргалант сум)	Хүүхдийн эмнэлгийн зориулалттай, А блок 21.30х12.80м, 32х15м 4 давхар 50 ортой барилга	4,898,999,204.00	2020.12.11	БУА/79/2020	Ховд аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төв (Ховд аймгийн Жаргалант сум)
НИЙТ ДҮН			61,326,126,813.00			
			(жаран нэгэн тэрбум гурван зуун хорин зургаан сая нэг зуун хорин зургаан мянга найман зуун арван гурван төгрөг)			